

09.15.2006

INVESTMENT OPPORTUNITIES IN  
THE FOOD AND AGRICULTURE SECTOR

Speaker: H.E. Mr. D. Terbishdagva, Member of the  
Cabinet, Minister of Food and Agriculture

Ladies and Gentlemen,

First of all, I would like to extend my sincere gratitude to the participants of the forum, international banking and financial organizations, members of the diplomatic corps, representatives of foreign businesses interested in investing in Mongolia, national business leaders and other representatives of the business community.

Concerned with sustainable economic growth in the region, the Government of Mongolia attaches great importance to the development of the food and agricultural industry and the improvement of the capacity to manage risk in the sector. The transition from the socialist system to a free market economy is nearly completed throughout the country, and citizens and entities are becoming adapted to the new system. Last year, the country's GDP increased by 5.4%. These positive developments can be seen in the food and agriculture sector, which produces 21.7% of the GDP and 13 percent of the foreign cash flow comes from the export of agricultural-originated products.

The livestock sector produces 80 percent of the total agricultural production. The livestock number has increased in the last three consecutive years, reaching 30.4 million heads by end of 2005. That is 2.4 million head more or an 8.5 % increase compared to previous year. By end of this year, it expects to reach about 32 million heads of livestock.

In 2006, it is estimated that Mongolia will harvest more than 130,000 tons of crop and 156,000 tons of potatoes and vegetables, which will be a 70% increase in crop and a 10% increase in potato and vegetable production compared to previous year. The food sector employs 13% of the total workers in the industrial sector and produces 12 percent of the total industrial output.

I am confident that this forum will make a substantial contribution to consolidate and build upon these positive developments, to explore new options for increasing domestic and foreign investment in the agricultural sector and to exchange opinions on problems within the sector and discuss ways in which they may be resolved.

In this regard, let me briefly introduce' the advantages and disadvantages of investment in the food and agriculture sector, as well as ways to improve an investment efficiently.

The population of Mongolia, as well as foreign tourists are likely to increase in coming years, leading to an expected sharp increase in the demand for food by consumers. Currently domestic

production satisfies its own food consumption for major table food products such as 20-25% of flour, 70% of potato and 53% of vegetables demand.

Consumption of nutrient and mineral-rich foods such as fish, eggs, vegetables and fruit among our population is insufficient. Mongolia imports many food products such as rice, vegetable oil, sugar and butter.

Because of its low population and livestock density, it has a low probability for the outbreak of animal diseases and our livestock is well adapted to the harsh continental climate, decreasing production costs of animal husbandry and creating opportunities for ecologically pure agricultural products. There are many advantages such as unpolluted fertile soils for farming is available.

Mongolia's extreme continental climate and long sunny days lead to a natural cleansing process that reduces pest, viral and other infections. Also, because of the extensive photosynthetic periods, higher quality products and higher yields can be harvested.

Since chemical enterprises are not developed in Mongolia, plant protection materials, fertilizers, different hormones and substances for speeding up plant and animal growth are not produced domestically that makes Mongolian produced livestock and crop products generally to be ecologically clean. In future, in order to intensify livestock and crop production farming, we are planning to utilize new modern scientific achievements and technologies in very appropriate ways.

I would like to draw your attention to the following in order to promote investing in the food and agriculture sector and develop cooperation among interested parties.

1. The legal environment of the sector is relatively favorable for making investments. The Parliament enacted the Government Policy on Food and Agriculture in 2003 that sets forth the main measures to develop the sector until 2015. This year, we jointly with ADB, we have formulated Agriculture's sector strategy in order to implement the above mentioned strategy.

The legal basis such as the amended Land Law, adoption of the Law on the Allocation of Land to the Citizens of Mongolia, Crop Law, Law on Land Fee and its associated Government decree, which sets the maximum land fee to be less than 0.5 USD per ha, have created very favorable conditions for crop and intensified livestock farmers. As well imported seed and domestically processed meat are subject to exemption from VAT. In addition, imported high quality breeding livestock and pigs are exempted from custom's tax. During period of August to April, custom taxes for potato and vegetables increases 3 times in order to support domestic production. This year, amendments were made in the Tax Law by changing taxation classification, reducing VAT from 15% to 10% and also formulated that import and custom tax's and VAT would be decreased for foreign investors in the major economically prioritized sectors, including food and agriculture.

2. A healthy banking and financial sector has been developed, resulting in the provision of quality financial services. The inflation rate has stabilized and fluctuations are of the order of decimal points only. The capacity of commercial banks to provide financial service has improved, bureaucratic inconveniences related to lending services have been reduced. People have started to

use their loans efficiently and their solvency has improved as a result. Consequently, the number of non-performing loans has decreased year by year.

3. There is great potential and interest, to export final products to international markets by processing raw materials from livestock such as meat, milk, wool, cashmere, intestines, animal skins and leather, rather than just raw materials. Annually, Mongolia supplies more than 200 tons of carcass meat, 277,000 tons of milk, 6,0-8,4 million skins, 17,000 tons of wool and 3,000 tons of cashmere..

4. Within the crop sector, there is the potential to increase domestic and foreign investment aimed at intensifying production. In 1990, a total of 1.3 million hectares of land was under cultivation. The abrupt privatization of large (collective-and state-owned) farms at the beginning of the transition period caused more than 690 million hectares of cultivated land to be abandoned, resulting in a sharp drop in national agricultural output. There are also available more than 300 thousand ha of flat land with water resources possible for irrigation, of which only 15% is being utilized. In the Dornod region, 290 thousand ha of arable land, which has not been utilized for crop production is available.

5. Many possibilities exist to increase investment in domestic processing industries utilizing cheap but quality raw materials. Many small and medium scale industries have been established that use modern technologies and adhere to the hygiene and sanitary requirements of the food industry; products and packaging have been Improved.

A number of slaughterhouses and "simple" processing plants have been established throughout the country, 28 large and small-scale industries capable of supplying more than 70,000 tons of carcass meat are operating. The number of dairy processing plants has been twofold compared with 1999 and, as of today, the number has reached 33 As a result, the volume of processed milk has increased.

More than 130 small and medium-scale factories, capable of producing flour for the domestic market are in operation. The production of food items such as bread, pastry, noodles and soft drinks has increased and competition amongst producers is increasing. The food industry has grown 2.1-3.3% during the past 3 years. But the main objectives of our food industry are to introduce new technologies, to increase labor productivity, to provide the domestic market with quality goods and support production of import substitution activities, and to increase exports. Therefore, today there is still a high demand for investment in the sector.

6. The professional and capable human resource of the sector will play a significant role in increasing the efficiency of investments. This year 45% of total population live and work in rural areas. Agriculture sector professionals are trained mainly at the Mongolian National Agricultural University, the Science and Technological University, as well as in several colleges and schools at the provincial and local level for the purpose of training professional workers and technicians. Also, several institutions are conducting research studies in the livestock, agriculture and veterinary fields. There are needs to make more investment to improve their capacity building and material basis in order to increase quality of education and training and strengthen research studies and training activities.

7. The Government of Mongolia has consistently pursued a policy of support for the development of open cooperation and free market relationships, in line with modern globalization. Its membership in the World Trade Organization, the UN's Food and Agriculture Organization and the International Organization of Animal Health enables Mongolia to export and import food and agricultural raw materials and products. Neighboring countries such as China and Russia traditionally import large amounts of agriculture products and raw materials that creates a substantial advantages in terms of geographical location and capacity.

8. Experience has been gained in implementing foreign programs and projects, cooperating with international agencies. Reliable business partnerships have already been established. Since the transition to a free market economy, a total of 60 foreign projects and programs were, and are being implemented, funded by foreign countries and organizations, amounting to \$300 million in the food and agricultural sector. Fifty percent of the mentioned projects are funded through grants while others are through loans. Foreign programs and projects should be directed to attracting foreign investment and in developing cooperation.

Although there are many advantages and favorable conditions for investment, the risks and disadvantages should also be taken into account. For instance, social factors such as poor infrastructure and old and dilapidated heating systems, weak water and electricity infrastructure and isolation to markets are still existing in rural areas. Agricultural enterprises remain widely scattered, as do their labor forces.

It is crucial for all investors and interested parties to take into consideration the present level of the food and agriculture sector and its economic and legal environment as well as the above mentioned advantages and disadvantages when considering investment.

I would like to address some of issues that are prioritized and require investment in the food and agriculture sector.

1. Developing meat and dairy intensified farming for the purpose of supplying larger cities and settlements with higher population density.
2. Establishing Feed-lot farming for exporting beef, mutton, pig and horse meat in crop producing regions.
3. Implementing large scaled project on utilization of water sources and development of irrigated agricultural production
4. Manufacturing and processing ecologically clean final products such as skin, meat, wool and cashmere.
5. Producing and exporting a cultivated fodder without any chemical fertilizers and supplying farmers, who are engaged in producing ecologically clean products through environment friendly technologies.

6. Planting irrigated crop, vegetable, potato, raps, fruit and fodder plants, processing vegetable oil for using food and petroleum consumption.
7. Marketing ecologically clean, luxury-brand products at domestic and international markets by improving food processing, packaging and hygiene and quality standards; introducing biotechnology achievements in the livestock sector.
8. Establishing breeding nucleus herds of meat, milk and other high-quality domestic breeds and marketing semen, embryos and breeding animals.
9. Manufacturing and marketing veterinary drugs and preparations
10. Establishing repairing stations for installing small and medium sized agricultural techniques
11. Starting leasing services for agricultural machineries and techniques
12. Manufacturing chemical and biological fertilizers
13. Manufacturing an irrigation equipments, plastic materials for green houses and wires for fencing. These are samples of many activities which are in demand and also possible to start in Mongolia.

In summary, the Mongolian Government has encouraged domestic and foreign investment by formulating objectives, setting priorities and issuing policies in a favorable legal environment, a relatively favorable tax, customs and trade environment and a stabilized and functioning banking and financial system. This concludes my brief presentation on investment opportunities in the food and agriculture sector.

I wish you all the best and successful business ventures.

Thank you for your attention.

“МОНГОЛ УЛС: Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт 2006”

Улаанбаатар хот

2006.09.15

“ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ  
БОЛОМЖ”

Илтгэгч: Монгол Улсын Засгийн газрын гишүүн,  
Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва

Хадагтай, ноёд оо!

Юуны өмнө энэхүү чуулга уулзалтанд оролцож буй олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаад орнуудын дипломат ажилтнууд, Монголд хөрөнгө оруулахыг сонирхогч орнуудын бизнесийн төлөөлөгчид, дотоодын аж ахуйн нэгжийн удирдлага, ажил хэрэгч хүмүүс Та бүхэнд гүн талархалаа илэрхийлье.

Монгол Улсын төр, Засгийн газар улс орны эдийн засгийн өсөлт, хөдөөгийн тогтвортой хөгжлийг хангахад хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, салбарын эрсдэл даах чадавхийг дээшлүүлэх асуудал шийдвэрлэх ач холбогдолтой гэж үзэж их анхаарал тавьж байдаг юм. Улс орны хэмжээгээр нийгмийн шинэ тогтолцоонд шилжих үйл явц төгсгөлийнхөө үед орж, төр, эдийн засгийн байдал тогтворжин зах зээлийн харилцаа төлөвшин хөгжиж, материал баялагийн үйлдвэрлэлд ахиц дэвшил гарч байна. Өнгөрсөн онд дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.4 хувиар өссөний дотор хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин дээшилж, газар тариалан, мал аж ахуй, хүнсний салбарт нааштай өөрчлөлтүүд бий болов. Хөдөө аж ахуйн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 20 гаруй хувийг үйлдвэрлэж байгаагийн зэрэгцээ улсын нийт валютын орлогын 13 хувийг хүнс, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортоос олж байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 гаруй хувь нь ноогдож буй мал аж ахуйн салбарт 170 гаруй мянган малчин өрх хөдөлмөрлөж байна. Мал сүргийн тоо сүүлийн

3 жил дараалан өсч 2005 оны эцсээр 30.1 саяд хүрч урьд оныхоос 2.1 саяар буюу бараг 10 гаруй хувиар нэмэгдлээ.

Газар тариалангийн салбарт 2005 онд 75.0 мянган тонн үр тариа, 146 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авснаар дотоодын гурилын хэрэгцээний 28 хувийг, төмс хүнсний ногооны 60 гаруй хувийг хангаж байна. Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, хууль эрх зүйн нөхцөл бүрдэж, өрх, гэр бүлийн хэрэгцээнд газрыг өмчлүүлэх, тариалангийн газрыг эзэмшүүлэх ажил эрчимтэй явагдаж байна.

Улсын хэмжээнд хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 1800 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж тэдгээрт аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 13 хувь нь ажиллаж, аж үйлдвэрийн бүтээгдхүүний 12 хувийг үйлдвэрлэж байна. Хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэл 2005 онд урь оныхоос 2 орчим хувиар нэмэгдлээ.

Бий болсон нааштай ахиц өөрчлөлтийг бататган хүнс, хөдөө аж ахуйн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг тодорхойлох, учирч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар санал бодлоо солилцох зорилгоор энэхүү чуулга уулзалтыг зохион байгуулж байна.

Үүнтэй холбогдуулан хүнс, хөдөө аж ахуйн салбар дахь хөрөнгө оруулалтын давуу болон эрсдэлтэй тал, өнөөгийн хэрэгцээ хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх арга замын товч танилцуулья.

### **Нэг. Салбарын хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлага.**

Монгол улсын хүн ам ойрын хорин жилүүдэд нилээн өсөх хандлагатай байгаа бөгөөд үүнтэй холбогдон хүнс, өргөн хэрэглээний барааны эрэлт хэрэгцээ ихээхэн нэмэгдэнэ. Одоогийн байдлаар хүн амын хүнсний үндсэн хэрэгцээ болох улаан буудайн гурил, төмс, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн дотоодын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Хөдөөгийн хүн амын хүнсний хэрэглээнд мах, сүү, гурил зонхилж байгаа төдийгүй нийт хүн амын хүнсний бүтцэд загас, өндөг, жимс жимсгэнэ зэрэг бичил махбодь, амин дэм бүхий бүтээгдэхүүний хувийн жин маш бага байна. Хөрш ОХУ, БНХАУ болон бүс нутгийн орнуудад эдийн засгийн хөгжлийн хурдац амьжиргааны түвшний өөрчлөлттэй уялдан экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өсөх төлөвтэй байна.

Иймд манай улс хөдөө аж ахуйдаа тэргүүлэх ач холбогдол өгч тогтвортой хөгжих нөхцөл бүрдүүлэх нь зайлшгүй. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн зэрэгцээ, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхэлж нэгжээс авах ашиг шим бүтээгдэхүүнийг дээшлүүлэх нь чухал байна. Энэ нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, материал техник хангамжийг сайжруулах, үйлдвэрлэлд илүү боловсронгуй технологи нэвтрүүлэхийг шаардаж байгаа хэрэг. Иймм учраас энд оролцож байгаа Та бүгдийг Монгол улсын хөдөө аж ахуй хүнсний салбарт хөрөнгө оруулах боломжийг сайтар ашиглаж, үр ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэхийг уриалж байна.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах өөрийн гэсэн давуу тал манайд байгааг Та бүхэн анзаарч анхааралдаа авахыг хүсч байна.

1. Салбарын эрх зүйн орчны хувьд хөрөнгө оруулалтыг татах харьцангуй таатай нөхцөл бүрдсэн гэж хэлж болно. УИХ 2003 онд “Төрөөс хүнс хөдөө аж ахуйн салбарт талаар баримтлах бодлого”-ыг батласан нь салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгов. Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж өгөөж, үр шимийг нь дээшлүүлэхийн тулд газрын харилцааны шинэтгэлийг хэрэгжүүлж тэнд хөрөнгө оруулах шаардлага өндөрт тавигдах боллоо. “Газрын тухай” хуулийг шинэчлэж, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийг батлан гаргасан нь энэхүү шинэчлэлийн эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Түүнчилэн “Тариалангийн тухай” хуулийг батлан гаргаад байна. Энэхүү хуулинд тариалангийн талбайг зүй зохистой ашиглах, хөрсний үржил шим, ургацыг хамгаалах, тариалангийн газрыг гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд ашиглах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон болно.

Манай улсын татвар, гаалийн тухай, гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиуд, тэдгээрийг үндэслэн Засгийн газраас гаргасан шийдвэрт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад хөнгөлөлт үзүүлэх тодорхой заалтууд тусгагдсан байгаа. Тухайлбал Засгийн газраас

гаргасан /2001 оны 140-р/ тогтоолд үр тариа, жимс, чихрийн манжин, тосны болон малын тэжээлийн ургамал тариалах, сүү, махны чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, мах махан бүтээгдэхүүн, гурил, малын тэжээлийн үйлдвэрийг тэргүүлэх ач холбогдолтой гэж үзэж энэ чиглэлийн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн технологийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмж, хүнд механизмыг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байхаар заасан байдаг.

2. Банк, санхүүгийн сүлжээ эрүүлжиж, орон нутагт үйл ажиллагаа явуулах тогтолцоо бүрдлээ. Мөнгөний ханш тогтворжиж, инфляцийн түвшин нэг оронтой тоонд хэлбэлзэж байна. Арилжааны банкуудын санхүүгийн чадвар сайжирч зээл олгоход хүнд суртал, чирэгдэл багаслаа. Хүмүүс зээлийг үр дүнтэй ашиглах сонирхолтой болж зээлийн төлбөр хийх чадвар сайжирч байгаагаас өр авлагад чанаргүй зээлийн эзлэх хувийн жин буурч байна.

Эрх зүйн таатай орчин бүрдэж макро эдийн засгийн орчин тогтворжихийн хирээр бодит эдийн засагт хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байна. Сүүлийн дөрвөн жилд улсын төсвөөс оруулсан нийт хөрөнгө оруулалт өмнөх дөрвөн жилтэй харьцуулахад . . .дахин, гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын хэмжээ . . . дахин өслөө. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт оруулсан хөрөнгийн хэмжээ ч нэмэгдэж байна.

3.Манай хөдөө аж ахуй, хүнсний салбарт хөрөнгө оруулалтыг татах давуу байдал, өөрийн онцлог тал ч бас бий. Мал аж ахуйн салбарын үндсэн түүхий эд болох мах, сүү, ноос, ноолуур, өлөн, арьс, шир зэргийг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулж зах зээлд гаргах их ирээдүйтэй юм. Өнөө эдгээр түүхий эдийн ихэнх хэсгийг хагас боловсруулсан буюу түүхийгээр нь экспортлож байна. Одоогийн байдлаар манай улс 30.1 сая малтай, жилд нядалгааны жингээр 200 гаруй мян.тн мах, 277 мян.тн сүү, 8.4 сая арьс, шир, 17.0 мян.тн хонины ноос, 3.0 мян. шахам тн ноолуур бэлтгэж зах зээлд гаргаж

байна. Ийм ч учраас Засгийн газар мал аж ахуйн үйлдвэрлэлийг байгаль, цаг уурын эрсдлээс хамгаалах чадавхийг дээшлүүлэх улмаар энэ салбарт хөрөнгө оруулагчид, хандивлагчдын анхаарлыг хандуулж зээл тусламжийг нэмэгдүүлэх, дотоодоосоо боломжийн хирээр хөрөнгө оруулалт хийж эрчимжүүлэлтийн зарим элементийг нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх бодлогыг тууштай баримталж ирлээ. Сүүлийн жилүүдэд малын чанар ашиг шимийг дээшлүүлэх, арчилгаа маллагааны шинэ технологи дээр түшиглэсэн суурьшмал өрхийн аж ахуйн эхлэл тавих, малчид, хөдөөгийн иргэд хоршиж ажиллах санаачлагыг дэмжих бодлого баримталж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

4. Газар тариалангийн хувьд гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх өргөн боломж бий. 1990-ээд онд улсын хэмжээнд 1.2 сая га тариалангийн эргэлтийн талбай ашиглаж байв. Зах зээлд шилжих үеийн огцом хувьчлалын бодлогоор томоохон аж ахуйнуудыг тараан хувьчилсан нь сайн үр дүн үзүүлээгүй төдийгүй 690 гаруй мянган га талбай ашиглагдахгүй орхигдож, тариалангийн эдэлбэр газрын хэмжээ буурахад нөлөөлсөн юм.

Тариалангийн үйлдвэрлэлд өндөр бүтээмжтэй техник, технологи, усалгаа, арвин ургацтай таримлын шинэ сорт нэвтрүүлэх, сайн чанарын үрээр тариалалт хийж эрчимжүүлэх үндсэн дээр га-аас авах ургацыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Энэ талаар өнгөрсөн дөрвөн жилд зарим алхам хийлээ. Юуны өмнө таримал ургамлын үрийн шинэчлэлт хийх, тариалан эрхлэх технологи үүний дотор уриншийн боловсруулалтыг сайжруулахад дэмлэг үзүүлэх бодлого баримтлалаа.

Сүүлийн 3 жилд газар тариалангийн салбарт нийтдээ 15.2 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлснээр тариалангийн үйлдвэрлэлд зохих хэмжээний өсөлт гарч байна. Хамгийн гол нь газар тариалангийн энэ өсөлт нь тариалсан талбайн өсөлтөөр биш, нэгж талбайгаас авсан

ургацын хэмжээ өмнөх гурван жилийн дунджаас **37.5-47.6** хувиар өссөн өсөлтөөр хангагдсан нь энэ талаар ахиц гарсныг харуулж байна. Газар тариалангийн бүтээгдэхүүний эрэлт цаашид улам нэмэгдэхийн дээр тариаланд тохиромжтой хангалттай талбайтай, Халх голын сав нутаг зэрэг нэмж ашиглах их талбай байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтыг энэ чигт нэмэгдүүлэх өргөн боломж байгааг харуулна.

5. Хямд өртөгтэй сайн чанарын түүхий эдэд тулгуурладаг үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд хөрөнгө оруулалтын хүрээг өргөтгөх боломж их байна. Хүнсний үйлдвэрүүдийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангасан орчин үеийн техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүд бий болж бүтээгдэхүүний нэр төрөл, сав, баглаа боодол сайжирч байна. Мал нядлах, эхлэн боловсруулах хэд хэдэн үйлдвэр шинээр байгуулагдаж ашиглалтанд орсноор улсын хэмжээгээр 70 гаруй мянган тонн тураг мах бэлтгэх хүч чадалтай том, жижиг 28 үйлдвэр ажиллах боллоо. Сүү, цагаан идээ боловсруулах жижиг, дунд үйлдвэрийн тоо 1999 оныхоос 2 дахин нэмэгдэж 33 үйлдвэртэй болсноор үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ нэмэгдэж байна.

Дотоодын хэрэгцээт гурилыг бүрэн үйлдвэрлэх хүчин чадал бүхий 130-аад том, жижиг үйлдвэр ажиллаж байна. Талх, нарийн боов, гоймон, амтат ус, ундаа зэрэг бүтээгдэхүүний нэр төрөл олширч, чанарын өрсөлдөөн бий болж байна. Сүүлийн 3 жилд хүнсний үйлдвэрлэл жил тутам 2.1-3.3 хувиар нэмэгдлээ. Гэлээ ч үйлдвэрт шинэ технологи нэвтрүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, чанар сайтай бүтээгдэхүүнээр дотоод зах зээлийг хангах улмаар импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх манай хүнсний үйлдвэрүүдийн чухал зорилт болж байна. Ийм учраас энэ салбарт хөрөнгө оруулах шаардлага өндөр хэвээр байна.

6. Хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний хангалттай нөөц байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй. Улсын хэмжээнд нийтдээ мал аж ахуй эрхэлдэг 172.4 мянган өрх, төмс, хүнсий ногооны аж ахуй эрхэлдэг 125.0 мянган өрх байгаа бөгөөд нийт ажиллагчдын 45 орчим хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл үндсэндээ хувийн өмч дээр суурилж байгаа учраас үйлдвэрлэл эрчимжүүлэх өмчийн эзний сонирхол, санаачлага илүү байгаа юм. Мөн боловсрол сайтай мэргэжлийн боловсон хүчнээр хангалттай дээр улсын хэмжээнд ажил эрхлэлтийн түвшин 60 орчим хувьтай байгаа бөгөөд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 33 мянга байгаа нь хэрэв нөхцөл нь бүрдвэл төв суурин газраас ч үйлдвэрлэлд гарч ажиллах харьцангуй хямд ажиллах хүч бий.

7. Монгол орон экологийн нөхцлийн хувьд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх харьцангуй давуу нөхцөлтэй юм. Хүн, малын нягтрал сийрэг тул мал, амьтаны аливаа өвчин тархан дэлгэрэх магадлал багатайн дээр мал сүрэг нв цаг уурын эрс тэс нөхцөлд зохицсон, хямд зардлаар өсгөн үржүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.

Газар тариалангийн хувьд унаган үржил шимээ хадгалсан хөрс бүхий их хэмжээний талбайтай. Байнгын нартай, эрс халуун, хүйтэн ээлжилсэн улиралтай учир тариалангийн талбайд байгалийн ариутгал тогтмол явагддагаас хортон шавьж, вирусын болон бусад төрлийн өвчин багатай, фотосинтезийн идэвхтэй цацрагийн хэмжээ хамгийн их байдгаас илүү амт чанартай ургац бүрэлддэг зэргийг дурдаж болох юм.

8. Гадаад, дотоод зах зээлийн өргөн боломж байгаа нь үйлдвэрлэлийг өргөжүүлэхэд чухал нөлөөтэй. Монгол Улсын төр, Засгийн газар орчин цагийн даяарчлалын үйл явцтай алхаа нийлүүлж нээлттэй гадаад хамтын ажиллагаа, чөлөөт зах зээлийн харилцааг хөгжүүлэх бодлогыг баримталж дэмждэг. Манай улс

Дэлхийн худалаадны байгууллага /WTO/, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /FAO/, мал амьтаны эрүүл мэндийн олон улсын байгууллага /OIE/ -ийн гишүүн тул хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг чөлөөтэй экспортлох, импортлох боломжтой байдаг.

Хөрш Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг манайхаас их хэмжээгээр импортолдог тул оновчтой байршил бүхий багтаамж сайтай гадаад зах зээлтэй гэж хэлж болно.

Хэвлэлийн мэдээнээс үзэхэд ОХУ, БНХАУ мах, улаан буудайн үлэмж хэсгийг импортоор авдаг нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг манайд үйлпвэрлэж экспортлох сайхан боломж байна гэсэн үг.

9. Салбарт гадаадын хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагааны дадлага туршлага бий болсон төдийгүй бизнесийн найдвартай түншлэлийн суурь бий болсон. Зах зээлийн эдийн засагт шилжснээс хойш Хүнс, хөдөө аж ахуйн салбарт гадаад орон, олон улсын байгууллагын зээл тусламжаар 300 сая орчим долларын өртөг бүхий 60 гаруй төсөл хөтөлбөр хэрэгжсэн буюу хэрэгжиж байна. Олон улсын байгууллага, гадаад орнуудын тусламжаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр төслүүдийн тэн хагас нь буцалтгүй тусламж бусад нь зээлийн хэлбэрээр хэрэгжиж манай салбарын үйлдвэрлэлд үр дүнгээ өгч байна. Цаашид гадаадын хөтөлбөр төслийг хөрөнгө оруулалтыг салбарт оруулах, үр дүнтэй хамтын ажллагаг өрнүүлэхэд чиглүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Ийнхүү хөрөнгө оруулалтын аятай таатай нөхцөлд, давуу тал олон байгаа ч зайлшгүй тооцож үзэх ёстой эрсдэл, сөрөг тал байгааг бас хэлэхгүй өнгөрч болохгүй. Тухайлбал улсын нийт нутаг дэвсгэрийн 40 гаруй хувь нь говь, цөлийн бүсэд хамрагддаг бөгөөд ган, зуд зэрэг байгалийн гамшигт өртөмтгий, хүн амын бараг тэн хагас нь байгалиас үлэмж хамааралтай бэлчээрийн гамшигт өртөмтгий, хүн амын бараг тэн хагас нь байгалиас үлэмж хамааралтай бэлчээрийн

мал аж ахуй болон эрчимжээгүй газар тариалан эрхэлдэг нь манай хөдөө аж ахуйн салбарын нэг онцлог юм.

Хөдөө дэх дэд бүтцийн хөгжил сул, зам харилцаа, дулаан, ус, эрчим хүчний хангамж сайнгүй, зах зээлээс алслагдсан зэрэг нийгмийн нөхцөл байдал ч хөдөө аж ахуйн салбарын хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байгааг үгүйсгэх аргагүй. Хөдөө аж ахуй эрхлэгчид хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн хоршиж чадаагүй, хувь хувиа аргацаасан тархай бутархай байдалтай байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн цар хүрээ, техник, технологийн түвшин, байгаль, цаг уурын эрсдэлээс шалтгаалан бүтээгдэхүүний чанар, хэмжээний хувьд өрсөлдөх чадвар сайн биш байгаа юм.

### **Хоёр. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж, арга зам**

Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн өнөөгийн төвшин, эрх зүй, эдийн засгийн орчин, салбарын үйлдвэрлэлийн дээр дурдсан давуутай болон эрсдэлтэй талыг тооцож бодитой алхам хийх нь хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэгч бүх этгээдэд ач холбогдолтой болно. Би энд манай улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүрээнд хөрөнгө оруулалт шаардлагтай, тэргүүлэх ач холбогдолтой гэж байгаа зарим асуудлыг хөндөж ярья.

1. Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх тар дундаа эрчимжсэн аж ахуйн чиглэлээр хөрөнгө оруулах хэрэгцээ өндөр байна. Ялангуяа Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсийн тулгуур төв, худалдааны чөлөөт бүсийн ойролцоо хүн амын нягтрал илүүтэй нутагт эрчимжсэн хөдөө аж ахуй бий болгон хөгжүүлэх хэрэгтэй байна.

Ийнхүү бүхэлд нь авч үзвэл салбарын хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлого зорилт тодорхой байгаагийн дээр хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн, татвар, гааль, худалдааны илт хөнгөлттэй нөхцөл, банк, санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдал зэрэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих нотолгоо болж байна. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага, боломж нөхцлийн талаар товч мэдээлэхэд ийм байна. Та бүхний ажил хөдөлмөрт амжилт хүсч сайн сайханыг хүсье.

## Анхаарал тавьсанд баярлалаа

Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх Засгийн газрын стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг байх нь зүйтэй гэж үзэж ХХААЯ-аас салбар, чиглэл бүрээр хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг гаргасан болно. Тухайлбал мал аж ахуйн салбарт Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалт, менежментийн хөтөлбөр, Эрсдэл даах чадавхи хөтөлбөр, Малын өвчлөлтийг хянах, халдварт өвчний тархалтын үед авах арга хэмжээг хөтөлбөр, Малын түүхий эд нийдүүлэгчид, боловсруулагчдын хоорондын холбоог бэхжүүлэх хөтөлбөр, Малын чанарыг сайжруулах хөтөлбөр, Газар тариалангийн салбарт Услалтын системийг засварлах, шинээр барих хөтөлбөр, Малын тэжээлийн зах зээлийг өргөжүүлэх хөтөлбөр, Төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг арилжааны чиглэлээр хөгжүүлэх хөтөлбөр, Үр, үржүүлэг, сорт гаргаж авах хөтөлбөр, Нийт салбарын хүрээнд Хөдөө аж ахуйг дэмжих үйлчилгээ хөтөлбөр, Урт хугацааны зээл авах боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөр, Хүнсний чанар, эрүүл ахуйн горимыг бэхжүүлэх хөтөлбөр, Хөдөө аж ахуйн салбарын бүтцийн зрхицуулалтын хөтөлбөр, Судалгааны хөтөлбөр зэрэг болно.